



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 456

Улаанбаатар хот

Г Магистр, докторын судалгааны ажлын  
үр дүнг хүлээлгэн өгөх журам тухай

Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь хэсэг, МУИС-ийн Дүрмийн 4.3.1, 4.3.8.4 дэх заалт, МУИС-ийн Захирлын 2019 оны А/341 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн санал, Захиргааны зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магистр, докторын судалгааны ажлын үр дүнг хүлээлгэн өгөх журмыг хавсралт ёсоор баталж, 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
2. Тушаал гарсантай холбогдуулан МУИС-ийн Захирлын 2010 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 176 дугаар тушаалаар батлагдсан “Докторын диссертацийн эх бэлтгэх, хэвлүүлэх, диссертаци, судалгааны үр дүнг хүлээлгэн өгөхөд баримтлах журам”-ыг 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сургалт, оюутан хариуцсан дэд захирал /Б.Очирхуяг/, Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа хариуцсан дэд захирал /Ч.Лодойравсал/, Ахисан түвшний сургуулийн бодлогын газрын дарга /Б.Энх-Амгалан/ нарт даалгасугай.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Я.ТӨМӨРБААТАР

3340300486

Захирлын 2020 оны ...дугаар сарын ...аны  
өдрийн...дугаар тушаалын хавсралт

1117144746  
УХД0072 9104399

## МАГИСТР, ДОКТОРЫН СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮНГ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журам нь (цаашид “журам” гэнэ) МУИС-ийн ахисан түвшинд суралцагчдын судалгааны ажлыг боловсруулах, үр дүнг хэвлүүлэх, номын санд хүлээлгэн өгөхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2 Ахисан түвшинд суралцагчдын судалгааны ажил нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2014 оны “Магистр, докторын сургалт эрхлэхэд баримтлах нийтлэг журам”, МУИС-ийн “Сургалтын журам”-ын заалтуудын нөхцөл, шаардлагыг хангасан байна.

ХОЁР. Ахисан түвшинд суралцагчдын судалгааны ажилд  
тавигдах ерөнхий шаардлага

2.1 Суралцагчийн (магистрант, докторант) судалгааны ажил (магистрантын хувьд магистрын судалгааны ажил, докторантын хувьд диссертаци) нь шинжлэх ухааны үндэслэлтэй, логикийн зөв дараалал, бүрэн төгс утгатай, хэлзүйн дүрмийн алдаагүй, ярианы болон этгээд бүдүүлэг, далд ёт утга бүхий үг хэллэг хэрэглээгүй байна.

2.2 Суралцагч нь судалгааны ажил бичихдээ хуурамч мэдээлэл оруулаагүй, судалгааны үр дүнг хуулбарлаагүй, үнэн зөв, хууль эрхийн хүрээнд хийсэн эсэхээ хянаж, эрдмийн ёс зүйтэй, зохиогчийн эрхийг хамгаалж, бусдын хийсэн судалгааны үр дүнг ишлэсэн байна.

2.3 Судалгааны ажил нь зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийг зөрчөөгүй болохыг “Бүтээлийн хуулбарлалтыг илрүүлэх систем” ашиглан МУИС-ийн хэмжээнд баталгаажуулна.

2.4 Суралцагч нь судалгааны ажлаа сургуулиас баталсан зохих загвар, шаардлагыг баримтлан бичсэн байна.

2.5 Судалгааны ажил нь “Төрийн болон албаны нууцын тухай” хуульд заасны дагуу нууцын зэрэглэлд хамаарах мэдээлэл, тоо баримтыг ашигласан бол судалгааны ажлын нүүр хуудсанд “Нууцын зэрэглэлтэй” гэж бичнэ.

2.6 Суралцагч болон судалгааны ажлын удирдагч нь дээрх ерөнхий шаардлагыг хангасан байх үүргийг хүлээнэ.

ГУРАВ. Судалгааны ажлын хэлбэржүүлэлт


3.1 Гадна хавтасны хэлбэржүүлэлт: Хавтасны загварыг Зураг 1-д харуулав.

3.1.1 Хавтас нь хатуу, хар өнгөтэй, текст нь алтан шаргал өнгөтэй байна.

3.1.2 Үсгийн фонт Unicode Standard-ийн Arial эсвэл Times New Roman байна.

- 3.1.3 МУИС-ийн лого нь хавтасны дээд хүрээнээс 1 см-ээс багагүй зйтай байна.
- 3.1.4 Логоны дор бичигдэх Монгол улсын их сургууль Бүрэлдэхүүн  
УХД0072 9104399  
сургуулийн нэрний фонтын хэмжээ 16pt байна.
- 3.1.5 Бүрэлдэхүүн сургуулийн нэрээс горилогчийн овог нэр хүртэлх зайд 3-4 см байх ба горилогчийн овог нэрний фонтын хэмжээ 16pt байна.
- 3.1.6 Горилогчийн овог нэрээс судалгааны ажлын сэдэв хүртэлх зайд 2 см-ээс багагүй байх ба судалгааны ажлын сэдвийн нэрний урт, богиноос шалтгаалан фонтын хэмжээ 22-28pt байна.
- 3.1.7 ..... ухааны докторын/магистрын зэрэг горилсон бүтээл нь судалгааны ажлын сэдвийн дор 1-2 см-ийн дор бичигдэх ба фонт нь налуу (Italic) хэлбэрээр 14pt хэмжээтэй бичигдэнэ.
- 3.1.8 Хотын нэр, он нь хавтасны доод хүрээнээс 2 см-ээс багагүй зйтай байх ба фонтын хэмжээ нь 14pt байна.

#### Зураг 1. Судалгааны ажлын гадна хавтасны загвар



#### 3.2 Үсгийн фонт

- 3.2.1 Суралцагчид судалгааны ажил бичихдээ зураг, хүснэгт, график, томъёо, хавсралт болон нэмэлт материалаас бусад үндсэн бүх бичиглэлийг нэг ижил үсгийн фонтоор бичнэ.
- 3.2.2 Гарчгийг тод /bold/ хэлбэрээр бичиж болох ба тухайн гарчиг эх текстээсээ дээд тал нь 2pt-ээр том байна. Эх текстийн үсгийн фонт 12pt байна. Үсгийн фонт Unicode Standard-ийн Arial эсвэл Times New Roman байна.

#### 3.3 Хуудасны захаас текст хүртэлх хэмжээ:

- 3.3.1 Хуудасны хүрээ нь дээд, доод, ба баруун захаас 25 мм, зүүн захаас 30 мм хэмжээтэй байна. Энэ хэмжээ судалгааны ажлын хавсралтад мөн адил мөрдөгдөнө.
- 3.3.2 Хуудасны дугаарлалт нь хуудасны доод захаас 1 см-ээс багагүй зйтай байна.

#### 3.4 Мөр хоорондын зайд ба хуудасны тохируулга:

- 3.4.1 Судалгааны ажлын үндсэн текстийн мөр хоорондын зайд 1.15-1.5 байна.

1117144746  
УХД0072 9104399

3.4.2 Хүснэгт, хуудасны зүүлт (footnotes), бүлгийн зүүлт (endnotes), график, зураг, тайлбар, нэмэлт тодруулга (glossary), хавсралт материал, ном зүй гэсэн хэсгүүдэд мөр хоорондын зай нь нэг буюу single байна.

3.4.3 Судалгааны ажлын бүлэг (Бүлэг 1, Бүлэг 2, Хавсралт материалын, Ном зүй) бүр шинэ хуудсанд эхэнэ.

3.5 Бүлэг, дэд бүлэг, дэд бүлэг доторх хэсгийн гарчиг:

3.5.1 Heading 1, Heading 2, Heading 3 гэх мэт Microsoft Word программын Styles хэрэгсэл ашиглан хийх ба үсгийн хэмжээ нь харгалзан 18 pt bold; 16 pt bold; 14 pt italic байна.

3.6 Хуудасны дугаарлалт:

3.6.1 Хуудасны дугаарыг диссертацийн эхнээс төгсгөл хүртэл нэгдсэн байдлаар хуудас бүрийн доод талын төв хэсэгт бичнэ. Дараах байдлаар дугаарлана. Үүнд:

- 1) Нүүр хуудсыг дугаарлахгүй.
- 2) Гарчиг, товчилсон үг, хүснэгт болон зургуудын нэрийн жагсаалт бүхий хуудаснуудыг ром тоогоор (i, ii, iii, ...) дугаарлана.
- 3) Судалгааны ажлын үндсэн текст, ишлэл хийсэн ном зохиолын жагсаалт, хавсралт, бүхий хуудаснуудыг араб тоогоор (1, 2, 3, ...) дугаарлана.
- 4) Footnote буюу хуудасны зүүлт хуудасны доор дараалсан дугаартай орох ба үсгийн хэмжээ нь 11pt байна.

3.7 Хүснэгт ба зураг/график:

3.7.1 Бүх хүснэгт, зураг/графикууд нь өөрийн давтагдахгүй дугаар, оноосон нэртэй байх ба хүснэгт, график тус бүр нь судалгааны ажлын үндсэн хэсэгт дугаар эсвэл оноосон нэрээрээ заавал дурдагдсан байна.

3.7.2 Хүснэгт ба зураг нь судалгааны ажлын туршид нэг дараалсан дугаарлалтаар (Хүснэгт 1-Хүснэгт X) эсвэл бүлэг тус бүрийн хувьд дараалсан нэршлээр (Хүснэгт 1.1-Хүснэгт X.X) 2 хэлбэрээр нэрлэгдэж болно. Энэ 2 хэлбэрийн аль нэгийг сонгоно.

3.7.3 Зураг, хүснэгтийн дараалсан дугаарлалтын ард түүний оноосон нэрийг бичих ба оноосон нэр нь тэдгээртэй нэг хуудсан дээр байрлана.

3.7.4 Оноосон нэр нь хэт товч, эсвэл хэт дэлгэрэнгүй байж болохгүй.

3.7.5 Хүснэгтийн оноосон нэр нь түүний зүүн дээд буланд байрлах ба хүснэгтийн дугаар, нэрийн хамт бичнэ. Бусад бүтээлээс авсан хүснэгт бол түүний эх сурвалжийг зүүн доод буланд нь бичнэ. Хүснэгтийн нэр ба агуулга, эх сурвалж дахь текстийн хэмжээ нь 11pt байна. (Жишээ Хүснэгт 1-ийг харна уу)

Хүснэгт 1. Оноосон нэр


Баганын нэр 1	Баганын нэр 2	Баганын нэр 3	Баганын нэр 4
Мэдээ 1.1	Мэдээ 2.1	Мэдээ 3.1	Мэдээ 4.1
Мэдээ 1.2	Мэдээ 2.2	Мэдээ 3.2	Мэдээ 4.2
Мэдээ 1.3	Мэдээ 2.3	Мэдээ 3.3	Мэдээ 4.3

Эх сурвалж: Эх сурвалжийн нэр

3.7.6 Зургийн оноосон нэр нь зүүн дээрээ байрлана. Зургийн дугаар, түүний нэрийг хамтад нь бичнэ. Нэр болон эх сурвалж нь 11рт хэмжээтэй байна. Бусад бүтээлээс авсан график бол түүний эх сурвалжийг зүүн доод буланд нь бичнэ. (Зураг 1)

Зураг 1. Зургийн оноосон нэр

1117144746  
УХД0072 9104399



Эх сурвалж: Эх сурвалжийн нэр

3.8 Судалгааны ажилд ишлэл авахдаа APA (American Psychological Association) хэв маягийг баримтална. Загвар 4-т заасан зааврын дагуу ишлэлийн бичиглэлийг боловсруулна.

3.9 Судалгааны ажлыг Монгол хэлээр бичих ба хамгаалуулах зөвлөлөөс зөвшөөрсөн тохиолдолд Англи хэлээр бичиж болно.

3.10 Судалгааны ажилд дурдагдаж буй гадаад хүний нэрийг Латин үсгээр бичнэ.

3.11 Суралцагч ямар программ дээр судалгааны ажлаа бичихийг хөтөлбөрийн тусгай шаардлага хэсэгт оруулж болно<sup>1</sup>.

#### ДӨРӨВ. Судалгааны ажлын бүтэц

4.1 Судалгааны ажлын удирдагч болон хамгаалуулах зөвлөлийн зүгээс зөвшөөрсөн тохиолдолд суралцагчийн судалгааны ажил нь 2-3 эссе (essay)-ээс бүрдсэн хэлбэртэй байж болно.

4.2 Судалгааны ажил нь дараах нийтлэг бүтэцтэй байна (Жишиг загварыг Загвар 2-оос харна уу). Үүнд:

- 1) Гадна хавтас
- 2) Нүүр хуудас
- 3) Зохиогчийн эрхийн хуудас
- 4) Талархал
- 5) Товчилсон үгийн жагсаалт
- 6) Хүснэгтийн жагсаалт
- 7) Зураг/графикийн жагсаалт
- 8) Судалгааны ажлын хураангуй

<sup>1</sup> Энд Microsoft Word, Latex болон судалгааны ажлын хэлбэржүүлэлтэд дурдсан стандартыг хангаж чадах бусад програм хангамжийг ойлгоно.



- 9) Гарчиг
- 10) Удиртгал/Оршил
- 11) Үндсэн бүлэг, дэд бүлэг, хэсгүүд (сэдвийн судлагдсан байдал; судалгааны онол, арга зүй; судалгааны үр дүн, хэлэлцүүлэг)
- 12) Дүгнэлт, санал зөвлөмж
- 13) Ном зүй
- 14) Хавсралт
- 15) Зохиогчийн эрхийн нотолгоо

4.3 Гадна хавтас: Суралцсан их сургууль, бүрэлдэхүүн/салбар сургууль, горилогчийн овог нэр, судалгааны ажлын сэдэв, . . . . . ухааны докторын/магистрын зэрэг горилсон бүтээл, хамгаалсан хотын нэр, оныг эхний нүүрэн дээр горилогчийн овог нэр, сэдэв, оныг арын нуруун дээр бичнэ.

4.4 Нүүр хуудас: Нүүр хуудасны загварыг Загвар 1-ийн дагуу боловсруулна. Нүүр хуудсанд горилогчийн харьялгадаж буй сургууль, тэнхимийн нэр, судалгааны нэгжийн нэр, суралцагчийн овог нэр, судалгааны ажлын сэдэв, суралцсан хөтөлбөрийн нэр, индекс, удирдагч, шүүмжлэгчийн нэр, хамгаалсан хотын нэр, оныг бичнэ.

4.5 Зохиогчийн эрхийн хуудас: Нүүр хуудасны дараагийн хуудсанд зохиогчийн эрхийг оруулахдаа хуудасны доод хэсгийн эхний мөрөнд ©20XX, хоёрдугаар мөрөнд горилогчийн ОВОГ НЭР бичнэ.

4.6 Талархал: Зохиогчийн эрхийн хуудасны дараагийн хуудсанд талархлын үг бичиж болно. Үнд судалгааны ажлыг бичих явцад тоон өгөгдөл цуглуулах, дадлага хийх, санхүүгийн болон сэтгэл зүйн дэмжлэг үзүүлсэн байгууллага, эрдэм шинжилгээний хүрээлэн, их сургууль, хувь хүнд баярлаж, талархсанаа илэрхийлж болно.

4.7 Судалгааны ажлын хураангуй: Судалгааны ажлын товч танилцуулга, зорилго, зорилтууд, хамрах хүрээ, арга зүй (үр дүнг тодорхойлоход ашиглагдсан үндсэн арга, аргачлалууд), үр дүн (судалгааны ажлаар тодорхойлогдсон үндсэн үр дүнгүүд), дүгнэлт (судалгааны ажлыг бүхэлд нь хамрах дүгнэлт) зэргийг багтаасан байвал зохино.

4.8 Гарчиг: Бүлэг, дэд бүлгүүд, хавсралтууд, ном зүй болон бусад шаардлагатай хэсгийг тэдгээрийн хуудасны дугаарын хамт жагсаана. Гарчгийн бүтэц, үндсэн хэсэг нь бүлгүүдэд хуваагдана. Бүлэг нь хэд хэдэн дэд бүлэгтэй байх тохиолдолд гарчигт зайлшгүй оруулна. Жишээлбэл: 3.1-р бүлэгт 3.1.1 гэсэн дэд бүлгийг оруулж ирвэл 3.1.2 гэсэн дэд бүлэг заавал байх ёстой. Гарчгийн агуулга нь зохиогч тухайн ажлын сэдвээ хэрхэн ойлгож бичсэнийг харуулж чадахуйц хэмжээгээр дэлгэрэнгүй, бүлэг, дэд бүлэг бүрийн агуулгыг бүрэн илэрхийлэхуйц, нуршаагүй, логик дараалалтай, ойлгомжтой байна.

4.9 Удиртгал/Оршил: Энэ хэсэгт судалгааны ажлын төрөл, зорилго, зорилтууд, судалгааны ажлын үндэслэл, сэдвийн хүрээнд хийгдсэн судалгааны ажлын өрөнхий танилцуулга, түүний ач холбогдол, үр дүнг хүртэгчид, ирээдүйн чиг хандлага, судалгааны ажлын гол үр дүнг товч дурдах, судалгааны ажлын зохион байгуулалт, бүлгийн дараалал, товч агуулгыг бичнэ.

4.10 Сэдвийн судлагдсан байдал: Тухайн сэдвийн хүрээнд өмнө хийгдсэн судалгааны үр дүн, аргачлал, хоорондын ялгаа, цар хүрээ, ангилал, заагийг өөрийн байр сууринаас, дүн шинжилгээнд суурилан тодорхойлно.

4.10.1 Судлагдсан байдал нь ангилсан, харьцуулсан, бүтээлч дүн шинжилгээ хийсэн хэлбэрээр бичигдэнэ. Гарын авлага, эрдэм шинжилгээний өгүүлэл, эрдэм шинжилгээний хурлын илтгэл, тайлан, цахим эх сурвалж, сонин сэтгүүлийн өгүүлэл зэрэг эх сурвалжийг судлагдсан байдалд багтааж болох ч сэдвийн онцлогоос хамааран эрдэм шинжилгээний өгүүллүүдийг чухалчилж үзнэ.

4.10.2 Сонгосон сэдвийн хүрээнд одоог хүртэл судлаагүй орхигдсон, эсвэл гүнзгийрүүлэн судлах шаардлагатай байгаа асуудлыг илрүүлэх замаар тухайн сэдвийг судлах болсон шалтгаанаа тайлбарлана.

4.11 Судалгааны онол, арга зүй:

4.11.1 Судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд ашигласан судалгааны бүтэц, арга зүйг тайлбарлаж, судалгааг хийсэн бодит үйл явцыг тодорхойлж бичнэ;

4.11.2 Судалгааны гол хувьсагч, хүчин зүйлүүдийн харьцаа, харилцан хамаарлыг онолын загвар, бүдүүвч, үзэл баримтлалын хүрээгээр тодорхойлох, гаргасан таамаглалыг батлах эсвэл няцаах онолын үндэслэлийг энэ хэсэгт гаргана;

4.11.3 Дэвшүүлсэн зорилтуудтай уялдуулсан байдлаар судалгааны арга зүйг тодорхойлох ба ашигласан анхдагч ба хоёрдогч өгөгдөл, баримтыг хэрхэн цуглуулсан аргачлалыг тайлбарлана;

4.11.4 Энд дараах дэд сэдвүүдийг оруулсан байна. Үүнд:

- 1) Объект буюу судалгаа хийгдсэн байршил;
- 2) Судалгааны арга, хэрэгсэл буюу өгөгдлийг цуглуулахад ашигласан арга;
- 3) Судалгааг гүйцэтгэхэд ашигласан материал;
- 4) Үйл явц буюу өгөгдлийг хэрхэн цуглуулсан болон боловсруулсан талаар, тэдгээрийн бүтэц, хэмжээ;
- 5) Өгөгдлийг задлан шинжлэхдээ ашигласан тоон болон чанарын судалгааны арга техник.

4.12 Судалгааны үр дүн, хэлэлцүүлэг:

4.12.1 Судалгааны өгөгдлийг задлан шинжлэхэд гарсан үр дүнг бичнэ;

4.12.2 Судалгааны асуултад хариулахад чиглэгдсэн нотлох баримт, математик загварчлал, статистик шинжилгээ, чанарын судалгааны үр дүн зэргийг багтаана;

4.12.3 Судалгаанд ашигласан өгөгдлийг зохистой хэлбэр (бүдүүвч, диаграмм, хүснэгт, зураг)-ээр илэрхийлэн харуулсан байна;

4.12.4 Өгөгдөл, мэдээлэл нь логик дараалал, уялдаа холбоотойгоор зохион байгуулагдсан байна;

4.12.5 Шинжилгээний үр дүнг томъёолсон байна;

4.12.6 Үр дүнгийн хэсэгт судалгааг гүйцэтгэх явцад тулгарсан хүндрэл, бэрхшээлүүдийг тодорхойлно;

4.12.7 Хэлэлцүүлэг хэсэгт гарган авсан үр дүн, дэвшүүлсэн асуулт, асуудлыг шийдвэрлэж, эсвэл таамаглалыг нотолж чадсан эсэх, бусад судлаачдын үр дүнтэй нийцэж эсвэл үгүйсгэж байгаа эсэх зэргийг шинжлэх ухааны үндэслэлтэй товч тодорхой, логик дэс дараатай тайлбарлана;

4.12.8 Үр дүнгийн бүлэг нь нэгээс олон дэд бүлэгт хуваагдаж болох ба дэд бүлэг бүр танилцуулга хэсэгтэй байна.

4.13 Дүгнэлт, санал зөвлөмж: Энэ хэсэгт зөвхөн өөрийн судалгааны үр дүнд гарсан дүгнэлтийг оруулна.

4.13.1 Тухайн ажлын үр дүнг нэгтгэн дүгнэж, шийдвэрлэсэн асуудал, хүрсэн үр дүнг товчлон дүн шинжилгээ хийх байдлаар бичих ба шийдэгдээгүй үлдсэн асуудал байвал түүний шалтгаан, цаашид судлах чиглэлийн талаар тусгана;

4.13.2 Санал, зөвлөмжийн хэсгийг энэ бүлэгт оруулна. Судалгааны үр дүнг практикт нэвтрүүлэх санал, түүнийг хэрэгжүүлэх зөвлөмж гаргаж болно. Санал, зөвлөмждөө бодлого, үйл ажиллагаа, үйл явцтай холбоотой саналыг нэмж оруулж болно;

4.13.3 Судалгааны үр дүнг цаашид хэрхэн хэрэглэх, боломж, анхааруулгыг тодорхой бичиж, зөвлөнө.

4.14 Ном зүй: Судалгааны ажилд ишлэгдсэн бүтээлүүдийг жагсаалт хэлбэрээр харуулна.

4.14.1 Судалгааны ажилд ишлэгдсэн нэг сэдэвт бүтээл, эрдэм шинжилгээний өгүүлэл, номын бүлэг, цахим эх сурвалжийг бичнэ.

4.14.2 Судалгааны ажлын ишлэлийг АРА стандарттаар бичнэ. Уг стандартын дагуу бүтээлийн төрөл тус бүрээр ном зүйг бичих зааврыг Загвар 3-т харуулав.

4.15 Хавсралт: Нэмж үзэх шаардлагатай хэсгийг (Хавсралт 1. Хавсралт 2... гм) дугаарлан тусгаж өгөх ба судалгааны ажилтай холбоотой нэмэлт материалуудыг агуулна. Дараах төрлийн бичиг баримт орж болно. Үүнд:

- 1) Судалгааны ажлын үндсэн бүлэг бүхий текстэд оруулахад хэт урт, нуршсан, эсвэл ач холбогдол бага мэдээлэл;
- 2) Судалгааны салбарын онцлогоос хамаарч судалгаа, туршилт хийх зөвшөөрөл хүссэн бичиг;
- 3) Ярилцлагын удирдамж, анкетын эх загвар, интервенц гүйцэтгэхэд хэрэглэсэн жишиг хичээлийн төлөвлөгөө гэх мэт судалгааны хэлбэр, үр дүнг сайтар ойлгоход чухал шаардлагатай материал;
- 4) Хуулийн хэсэг, албан баримтууд, зураг, түүвэр судалгааны асуулга;
- 5) Судалгааны ажлын тооцооллын явцын бичилт, тооцооны дэлгэрэнгүй үр дүн;

4.16 Зохиогчийн эрхийн нотолгоо: Горилогчийн зүгээс судалгааны ажлыг өөрөө хийсэн болох, Монгол улсын зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд заасны дагуу бусдын оюуны өмчийн эрхийг зөрчөөгүй болохоо нотолж баталгааны хуудас бичин гарын үсэг зурж хавсаргасан байна.

Судалгааны ажлыг "Бүтээлийн хуулбарлалтыг илрүүлэх систем"-ээр  
шалгуулах

5.1 Суралцагчийг жинхэнэ хамгаалалтад орохыг зөвшөөрсөн удирдагчийн тодорхойлолтод үндэслэн Номын сангаас тухайн судалгааны ажлыг "Бүтээлийн хуулбарлалтыг илрүүлэх систем"-ээр шалгасан тухай бичиг олгоно.

5.2 Уг бичигт бүтээлийн хуулбарлалт хийгдээгүй нь үнэн болохыг тодорхойлох ба ажлын 5 өдөрт багтаан олгоно.

5.3 Бүтээлийн хуулбарлалт хийгдсэн гэж тодорхойлогдсон тохиолдолд суралцагч нь жинхэнэ хамгаалалтаас өмнө дахин нэг удаа шалгуулна.

5.4 Номын сангаас МУИС-ийн хэмжээнд бүтээлийн хуулбарлалт хийгдсэн эсэхийг шалгасан бичиг аваагүй буюу хуулбарласан гэсэн дүгнэлт бүхий бичигтэй магистрантыг жинхэнэ хамгаалалтад оруулахгүй байх үүргийг магистрын судалгааны ажил хамгаалуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга хүлээнэ. Докторантын хувьд Ахисан түвшний сургалт хариуцсан нэгжээс Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд хургуулэх хамгаалалтад оруулахыг зөвшөөрсөн албан бичгийг олгохгүй.

ЗУРГАА. Судалгааны ажлыг хүлээлгэн өгөх

6.1 Жинхэнэ хамгаалалтын дараа суралцагч нь хамгаалалтын үед гарсан санал, шүүмжлэлийг бүрэн засварлаж, засварыг гарын үсгээр баталгаажуулан эцэслэж, судалгааны ажлын хоёроос доошгүй эх хувь дээр удирдагч, хамгаалуулах зөвлөлийн гишүүдээр гарын үсэг зуруулна. Магистрын судалгааны ажлын хувьд хэвлэмэл болон цахим хэлбэрээр МУИС-ийн номын санд хүлээлгэн өгнө. Докторын диссертацийн хувьд МУИС-ийн номын сан (хэвлэмэл болон цахим хэлбэрээр), Үндэсний номын сан, Шинжлэх ухаан, технологийн санд заавал хүлээлгэн өгнө.

6.2 МУИС-ийн номын санд хүлээлгэн өгөх хэвлэмэл хэлбэр нь Монгол улсын номын стандартын дагуу хуудасны 2 талд хэвлэсэн байж болно.

6.3 Судалгааны ажлын эцсийн хувилбарыг МУИС-ийн номын санд цахим хэлбэрээр CD эсвэл DVD дээр хуулж хүлээлгэн өгнө. CD, DVD-ний нүүрэн дээр судалгааны ажлын талаарх үндсэн мэдээллийг Загвар 5-д заасны дагуу хэвлэнэ.

6.4 МУИС-ийн номын санд хүлээлгэн өгснийг нотлох баримт нь магистр, докторын зэрэг олгох тушаал гаргахад шаардлагатай баримтын нэг болно.

6.5 МУИС-ийн номын санд судалгааны бүтээлийг хүлээлгэн өгөхдөө батлагдсан маятyg бөглөж, гарын үсгээр баталгаажуулан, бүтээлд хавсаргана.

6.6 Судалгааны ажлыг МУИС-ийн номын сан хүлээн авч фонд бүрдүүлэн, цахим болон цаасан хэлбэрээр уншлага үйлчилгээнд ашиглана.

Загвар 1. Нүүр хуудасны загвар

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ<sup>2</sup>  
БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛЬ

1117144746  
УХД0072 9104399

Харьяа тэнхим

Судалгааны нэгжийн нэр

СУРАЛЦАГЧИЙН ОВОГ НЭР

## СУРАЛЦАГЧИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН СЭДЭВ

Мэргэжлийн индекс: EXXXXXXX (Мэргэжил)

..... ухааны докторын/магистрын зэрэг горилсон бүтээл

Удирдагч: ..... / .....

..... / .....

Шүүмжлэгч: ..... / .....

УЛААНБААТАР ХОТ


2020

<sup>2</sup> Судалгааны ажлын сэдвийн нэрний урт, богиноос шалтгаалан фонтын хэмжээ 18-28 pt байх ба бусад бичиглэлийн хувьд 12 pt хэмжээтэй байна.

Загвар 2. Судалгааны ажлын бүтцийн жишиг загвар

Нүүр хуудас (Загвар 1)  
Зохиогчийн эрхийн хуудас

© 20XX  
ОВОГ НЭР



**Талархал**

Энэхүү судалгааны ажлыг бичих явцад бүхий л талаар зөвлөж, удирдан чиглүүлсэн удирдагч . . . . . , судалгааны өгөгдлийг боловсруулахад тусалсан. . . . . түүвэр судалгаа авах зардлыг санхүүжүүлсэн . . . . . захиралтай. . . . . ХХК-ийн хамт олон, судалгааны ажлыг хийхэд бүхий л талаар тусалж дэмжсэн гэр бүлийн гишүүд болох . . . . . , . . . . . нарт гүн талархал илэрхийлье.

**Товчилсон үгийн жагсаалт**

АХБ	Азийн хөгжлийн банк
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
WB	World bank

**Хүснэгтийн жагсаалт**

Хүснэгт 1. Мэдээллийн төрөл, дэд төрлүүд	X
Хүснэгт 2. Когнитив үйлийн дэд зэрэглэлүүд	XX
Хүснэгт N. Блумын таксономи	XX

**Зургийн жагсаалт (эсвэл графикийн жагсаалт)**

Зураг 1. Судалгаа хийсэн алхам	XX
Зураг 2. Судалгаа хийсэн алхам	XX
Зураг N. Судалгаа хийсэн алхам	XXX

**Судалгааны ажлын хураангуй**


**Гарчиг**

**УДИРТГАЛ/ОРШИЛ**

- Судалгааны үндэслэл
- Судалгааны асуудлын томъёолол
- Судалгааны асуултууд
- Судалгааны зорилго
- Судалгааны ач холбогдол
- Судалгааны ажлын бүтэц

## **БҮЛЭГ I.**

- 1.1
- 1.2



## **БҮЛЭГ II.**

- 2.1. Судалгааны дизайн
- 2.2. Судалгааны талбар
- 2.3. Судалгааны оролцогчид
- 2.4. Өгөгдөл цуглуулах арга хэрэгсэл
- 2.5. Өгөгдөл цуглуулах үйл явц
- 2.6. Өгөгдөл задлан шинжилгээ хийх
- 2.7. Ёс зүйн хэм хэмжээ
- 2.8. Судалгааны ажлын хязгаарлагдмал тал

## **БҮЛЭГ III.**

- 3.1.
- 3.2.

## **ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ**

- 1.
- 2.

### **Ном зүй**

- [1] Crum.R.L., Klingman. D.D., Tavis. L.A. (1983). An operational approach to integrated working capital planning. *Journal of Economics and Business*, 35(3,4), 343-378.  
[2] .....

### **Хавсралт**

#### **Зохиогчийн эрхийн нотолгоо**

Энэхүү судалгааны ажил нь миний өөрийн бүтээл бөгөөд Монгол улсын зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд заасны дагуу бусдын оюуны өмчийн эрхийг зөрчөөгүй болохоо нотолж байна.

.....  
/Овог, нэр/

.....  
/Гарын үсэг/

Загвар 3. APA стандартаар ном зүйг бичих заавар

НЭГ. Бүтээлийн төрөл, тэдгээрт хамаарах бичиглэлийн хэлбэржүүлэлт

Төрөл	Хэлбэржүүлэлт	Жишээ 7144746 <small>ХМН/729104299</small>
Сэтгүүлийн өгүүлэл (хэвлэмэл)	Зохиолчийн нэр, Овгийн үсэг. (Хэвлэгдсэн он). Өгүүллийн нэр. Сэтгүүлийн нэр, Дугаар (Issue), хуудас-хуудас.	Nevin, A. (1990). <i>The changing of teacher education special education</i> . Teacher Education and Special Education: The Journal of the Teacher Education Division of the Council for Exceptional Children, 13(3-4), 147-148. Сосорбурам, Л. (2010). Сургалтын үйл ажиллагаанд эцэг эхийн бодит оролцоог нэмэгдүүлэх боломж. <i>Боловсрол судлал</i> , 6(64), 49-55.
Сэтгүүлийн өгүүлэл (цахим)	Зохиолчийн нэр, Овгийн үсэг. (Хэвлэгдсэн он). Өгүүллийн нэр. Сэтгүүлийн нэр, Дугаар (Issue), хуудас-хуудас. doi:XX.XXXXXX эсвэл Эх сурвалжийг URL сэтгүүлээс	Jameson, J. (2013). E-Leadership in higher education: The fifth "age" of educational technology research. <i>British Journal of Educational Technology</i> , 44(6), 889-915. doi: 10.1111/bjet.12103
Ном (хэвлэмэл)	Зохиогчийн нэр, Овгийн үсэг. (Хэвлэгдсэн он). Номын нэр. Хэвлэсэн хот, Улс: Хэвлэлийн компани.	Finney, J. (1970). <i>Time and again</i> . New York, NY: Simon and Schuster.
Ном (цахим)	Зохиогчийн нэр, Овгийн үсэг. (Хэвлэгдсэн он). Номын нэр. [Цахим уншигчийн хувилбар]. эх сурвалж: http://xxxxx эсвэл doi:xxxxx	Eggers, D. (2008). <i>The circle</i> [Kindle Version]. Retrieved from <a href="http://www.amazon.com/">http://www.amazon.com/</a>
Цахим хуудас	<u>Зохиогчийн нэрийг оруулсан:</u> Зохиогчийн нэр, Овгийн үсэг. (Хэвлэгдсэн он, сар, өдөр). Өгүүллийн нэр. Эх сурвалжийг URL-ээс <u>Зохиогчийн нэргүйгээр:</u> Өгүүллийн нэр. (Хэвлэгдсэн он, сар, өдөр). Эх сурвалжийг URL-ээс	Simmons, B. (2015, January 9). <i>The tale of two Flaccos</i> . Retrieved from <a href="http://grantland.com/the-triangle/the-tale-of-two-flaccos/">http://grantland.com/the-triangle/the-tale-of-two-flaccos/</a>  Teen posed as doctor at West Palm Beach hospital: police. (2015, January 16). Retrieved from <a href="http://www.nbcmiami.com/news/local/Teen-Posed-as-Doctor-at-West-Palm-Beach-Hospital-Police-288810831.html">http://www.nbcmiami.com/news/local/Teen-Posed-as-Doctor-at-West-Palm-Beach-Hospital-Police-288810831.html</a>
Нэвтэрхий толь	Зохиогчийн нэр, Овгийн үсэг. (Хэвлэгдсэн он). Дотоод гарчиг.	Kammen, C., & Wilson, A.H. (2012). Monuments. In <i>Encyclopedia of local</i>

	Нэвтэрхий толийн нэр нэвтэрхий толиноос (Дуг. ХХ, хуудас. ХХ). Хот, Улс: Хэвлэлийн компани.	history. (pp. 363-364) Lanham, MD: AltaMira Press.
Тайлан	<u>Засгийн газар, байгууллага</u> Засгийн газар/байгууллагын нэр. (он). Тайлангийн нэр. Хот, Улс: Зохиогч. /онлайн бол энд "URL-ээс" гэж интернэт хаягийг нэмнэ/	Ministry of Health. (2008) <del>11714446 X079104399</del> Let's get real: Real skills for people working in mental health and addiction. Wellington, New Zealand: Author. Ишлэлд: (Ministry of Health, 2008)
	<u>Нэрлэсэн зохиогчтой тайлан</u> Зохиогчийн нэр, Овгийн үсэг. (он). Тайлангийн нэр. Хот, Улс: засгийн газар, байгууллагын нэр. /онлайн бол энд "URL-ээс" гэж интернэт хаягийг нэмнэ/	Else, A. (1997). Maori participation and performance in education: A literature review and research programme. Wellington, New Zealand: Ministry of Education. Retrieved from <a href="http://edcounts.squiz.net.nz/_data/assets/pdf_file/0017/7505/else-maori-summary.pdf">http://edcounts.squiz.net.nz/_data/assets/pdf_file/0017/7505/else-maori-summary.pdf</a> Ишлэлд: (Else, 1997)
	<u>Жилийн тайлан</u> Байгууллагын нэр. (он). Тайлангийн нэр. Хот, Улс: Зохиогч.	Heritage Mining. (1993). Annual report 1992. Auckland, New Zealand: Author Ишлэлд: (Heritage Mining, 1993)
	<u>Дугаартай жилийн тайлан</u> Байгууллагын нэр. (он). Тайлангийн нэр. (Тайлангийн дугаар) Хот, Улс: Зохиогч.	World Health Organization. (2003). Diet, nutrition and the prevention of chronic diseases. (WHO Technical Report series 916). Geneva, Switzerland: Author Ишлэлд: (World Health Organization, 2003)
Хэвлэгдээгүй эх сурвалж	Зохиогчийн нэр, Овгийн үсэг. (он). Эх сурвалжийн нэр. Хэвлэгдээгүй эх сурвалж/мэдээллийн сан.	Spud, I. H. (1999). Contrastive analysis: A comparison of Pig Latin and English. Unpublished manuscript.
Архивын баримт	Зохиогчийн нэр, Овгийн үсэг. (сар өдөр, он). Архивын баримтын нэр (хаяг/байрлал). Баримтын төрөл, Архивын газрын нэр, Байршил/байгууллага, Хот, Улс.	Busch, Joseph F. (August 10, 1914). Diocese of Lead application of aid (Series 5, Box 4, Folder 2). Bureau of Catholic Indian Missions Records, Department of Special Collections and University Archives, Marquette University, Milwaukee, WI. Johnny can read – Better than ever. (1958). Unidentified newspaper clipping (Series 10, File 01165). Photographic, Sound, Film,

		<p>and Biographical Records, Department of Special Collections and University Archives, Marquette University, Milwaukee, WI.</p> <p>Sullivan, Harold. (March 28, 1940). Letter from Harold Sullivan to Dorothy Day (Series W-4, Box 2). Dorothy Day-Catholic Worker Collection, Department of Special Collections and University Archives, Marquette University, Milwaukee, WI.</p>
Сонины мэдээ (хэвлэмэл)	Зохиогчийн нэр, Овгийн үсэг. (Жил, Сар өдөр). Мэдээний гарчиг. Сэтгүүлийн нэр, ху. xx- xx.	Rosenberg, G. (1997, March 31). Electronic discovery proves an effective legal weapon. <i>The New York Times</i> , p. D5.
Сонины мэдээ (цахим)	Зохиогчийн нэр, Овгийн үсэг. (Жил, Сар өдөр). Мэдээний гарчиг. Сэтгүүлийн нэр, URL- ээс	Rosenberg, G. (1997, March 31). Electronic discovery proves an effective legal weapon. <i>The New York Times</i> , Retrieved from <a href="http://www.nytimes.com">http://www.nytimes.com</a>

Загвар 4. Зохиогчийн тооноос хамааруулан ишлэлийг хэлбэржүүлэх

Зохиогчийн тоо	Бичиглэлийн хэлбэржүүлэлт	Жишээ
Нэг зохиогчтой	Зохиогчийн нэр, овгийн эхний үсэг. xxx <b>Ишлэлд:</b> (Зохиогчийн нэр, он)	Baataartogtox, Ц. (2012). xxx Berndt, T. J. (2002). xxx <b>Ишлэлд:</b> (Баатартогтох, 2012)
Хоёр зохиогчтой	1-р зохиогчдын нэр, овгийн эхний үсэг., & 2-р зохиогчдын нэр, овгийн эхний үсэг., xxx <b>Ишлэлд:</b> (1-р Зохиогчийн нэр & 2-р Зохиогчийн нэр, он)	Wegener, D. T., & Petty, R. E. (1994). xxx  <b>Ишлэлд:</b> (Wegener & Petty, 1994)
Гурваас таван зохиогчтой	1-р зохиогчдын нэр, овгийн эхний үсэг., 2-р зохиогчдын нэр, овгийн эхний үсэг., & 3-р зохиогчийн нэр, овгийн эхний үсэг. xxx <b>Ишлэлд:</b> (1-р Зохиогчийн нэр, 2-р Зохиогчийн нэр, & 3-р Зохиогчийн нэр, он)	Kernis, M. H., Cornell, D. P., Sun, C. R., Berry, T., & Bach, J. S. (1993). xxx  <b>Ишлэлд:</b> Анх удаа ишлэхдээ: (Kernis, Cornell, Sun, Berry & Bach, 1993) 2-дахь удаагаас давтан ишлэх бол: (Kernis et al., 1993) Монгол хэлээр бол: (Баяртогтох нар., 1998) Тухайн эрдэмтэн/бүтээлийн үзэл бодлыг илэрхийлсэн бол:

		xxx гэж Баяртогтох нар. (1998) үзжээ....
Зургаа буюу түүнээс олон зохиогчтой	<p>1-р зохиогчдын нэр, овгийн эхний үсэг., 2-р зохиогчдын нэр, овгийн эхний үсэг., 3-р зохиогчийн нэр, овгийн эхний үсэг., 4-р зохиогчийн нэр, овгийн эхний үсэг., 5-р зохиогчийн нэр, овгийн эхний үсэг., ...сүүлийн зохиогчийн нэр, овгийн эхний үсэг. xxx</p> <p><b>Ишлэлд:</b> (1-р Зохиогчийн нэр нар., он)</p>	Miller, F. H., Choi, M. J., Angeli, L. L., Harland, A. A., Stamos, J. A., Thomas, S. T., . . . Rubin, L. H. (2009). xxx 1117144746 УХД0072 9104399

Загвар 5. МУИС-ийн номын санд хүлээлгэн өгөх CD, DVD-ний нүүр загвар

